



Хууль эрх зүйн мэдээлэл #7



Монгол Улсын Засгийн газраас Монгол Улсад 2026 онд хөдөлмөр эрхлэх гадаад ажилтны тоо, хувь хэмжээг баталлаа.

Холбоо барих:

Серги Кобахидзе

Евроази хариуцсан Партнер
Татвар, Хуулийн зөвлөх үйлчилгээ
sergi.kobakhidze@pwc.com

Рагчаахүүгийн Мөнхжаргал

Хуулийн үйлчилгээний ахлах менежер
Татвар, Хуулийн зөвлөх үйлчилгээ
munkhjargal.ragchaakhuu@pwc.com

Чойжамцын Цэндмаа

Захирал
Татвар, Хуулийн зөвлөх үйлчилгээ
tsendmaa.choijamts@pwc.com


Отгонтогтоолын Мөнхнасан

Ахлах хуульч
Татвар, Хуулийн зөвлөх үйлчилгээ
munkhnasan.otgontogtool@pwc.com

Өмгөөллийн

ПрайсуотэрхаусКүүпэрс Легал ХХН

Сентрал Тауэр, 6 давхар
605 тоот, Улаанбаатар
14200, Монгол улс
Утас : + 976 70009089
www.pwc.com/mn



Хураангуй

2025 оны 10-р сарын 1-ний өдөр Монгол Улсын Засгийн газраас 113 дугаар тогтоолоор Монгол улсад 2026 онд хөдөлмөр эрхлэх гадаад ажилтны тоо, хувь хэмжээг баталлаа. 2026 оны хувьд зөвхөн хоёр салбарт гадаад ажилтны тоог тогтоосон бөгөөд бусад салбарын хувьд хязгаарлалт тогтоогоогүй байна.



Ерөнхий мэдээлэл

Монгол улсын Засгийн газраас жил бүр Монгол улсад үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээдэд ажиллаж болох гадаад ажилтны тоог баталдаг. 2022 оны 7-р сарын 1-ний өдрөөс эхлэн үйлчилж эхэлсэн Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн

22.1 дүгээр зүйлд заасны дагуу ийнхүү Засгийн газраас жил бүрийн 10-р сарын 1-ний өдрөөс өмнө Монгол Улсад хөдөлмөр эрхлэх гадаад ажилтны тоо, хувь хэмжээг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар тогтоодог.



2026 оны гадаад ажилтны тоо

Монгол Улсад 2026 онд Төрийн удирдлага, батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал болон Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагааны салбарт хөдөлмөр эрхлэх гадаад ажилтны тоог нарийвчлан тогтоосон. Бусад бүх салбарын хувьд хөдөлмөр эрхлэх гадаад ажилтны тооны хувьд аливаа хязгаарлалт тогтоогүй байна.

Салбар	Гадаад ажилтны тоо
Төрийн удирдлага, батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	130
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	600
Бусад салбар	-

Ихэнх салбарт ажиллах гадаад ажилтны тоог тогтоогоогүй нь “Шинэ сэргэлтийн бодлого”-д тусгагдсан тусгай зөвшөөрөл, төрийн хүнд суртлыг бууруулах бодлогын нэгэн илрэл юм. Сүүлийн жилүүдэд гадаад ажилчдын тооны хувьд хязгаарлалт тогтоосон салбарын тоо тогтвортой буурсан. 2023 онд Монгол Улс 21 салбарт гадаад ажилчдын тоонд тодорхой хязгаар тогтоож байсан бөгөөд 2024, 2025 онуудад зөвхөн цөөн салбарт гадаад ажилтны тоог тогтоох болсон. 2026 онд ч мөн энэ чиг хандлага үргэлжилж, зөвхөн хоёр салбарт хязгаарлалт тогтоож бусад бүх салбарт хязгаарлалт тогтоогоогүй байна.



Бидэнтэй холбогдоорой

Хөдөлмөрийн тухай хууль болон холбогдох бусад хууль журамтай холбоотой хууль зүйн зөвлөгөө авахыг хүсвэл бидэнтэй холбогдоорой. **Батлагдсан тогтоолтой энд дарж танилцана уу.**

www.pwc.com/mn

Энэхүү мэдээллийг Өмгөөллийн ПрайсуотэрхаусКүүпэрс Легал ХХН бэлтгэсэн болно. Энд дурдсан мэдээлэл нь зөвхөн ерөнхий мэдээлэл өгөх зорилготой бөгөөд хуулийн зөвлөгөө биш юм. Аливаа үйлдэл (эс үйлдэхүй) хийхээс өмнө уншигч та өөрийн нөхцөл байдалд тохирсон тусгайлан мэргэжлийн зөвлөгөө авах нь зүйтэй. Энэ мэдээлэлд үндэслэн хийсэн үйлдэл, эс үйлдэхүйн хувьд бид аливаа хариуцлага хүлээхгүй болно.

© 2025 Бүх эрх нь хамгаалагдсан. Энэхүү мэдээлэлд дурдагдсан “PwC” нь PricewaterhouseCoopers International Limited (PwCIL)-ийн гишүүн байгууллага болох Өмгөөллийн ПрайсуотэрхаусКүүпэрс Легал ХХН-ийг илэрхийлнэ.